



II байр
С.Гантулга, оюутан
МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль,
Маркетингийн 2-р анги

12-сарын 1. Дэлхий нийтээрээ ДОХ-той тэмцэх өдөр

2004 оны 12-р сарын 1-ний дэлхий нийтээрээ ДОХ-той тэмцэх өдөр “Эмэгтэйчүүдийг ДОХ-оос хамгаалья” уриан дор болж өнгөрлөө. Энэ өдөрт зориулан Монголын Хүн ам ба Хөгжил Нийгэмлэгийн дэргэдэх “Залуу хүн ам зүйч” клуб, МУИС-ын Оюутны Холбоо-Оюутан конгресс хамтран “ДОХ-бидний амьдралд” сэдэвт 5 өдрийн аянг 2004 оны 11-р сарын 27-ноос 12-р сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулав.

Аяны өдрүүдэд МУИС-ийн оюутны дотуур байрууд, хичээлийн байруудаар ДОХ-той тэмцэх видео ухуулга, сурталчилгааны ажлуудыг амжилттай зохион байгуулаа.

Энэ аяны хүрээнд МУИС-ийн нийт оюутнуудын дунд ЭССЭ-нийтлэлийн уралдаан зарласан бөгөөд, уралдаанд нийт 50 гаруй оюутан бүтээлээ ирүүллээ. Эдгээр бүтээлүүдээс МУИС-ын НШУС-ийн философиийн 4-р ангийн оюутан Ж.Энхжаргал “Хэнд, яж, ямар аргаар” сэдэвт бүтээлээрээ I байр, МУИС-ийн ЭЗС-ийн Маркетингийн 2-р ангийн оюутан С.Гантулга “Хүн төрөлхтөн, дэлхий сртөнцөд нүүрлэсэн аюул” бүтээлээрээ II байр, МУИС-ийн ЭЗС-ийн даатгалын 3-р ангийн оюутан Ш.Мөнхцэцэг “ДОХ-бидний амьдралд” бүтээлээрээ III байр эзэлж 5000-15000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнагдлаа. МУИС-ийн НШУС-ийн нийгмийн ажилтны 4-р ангийн оюутан Х. Ариунзул, МУИС-ийн МКС-ийн программ хангамжийн 1-р ангийн оюутан Ч.Сүхбаатар нарын бүтээл тусгай байрт шалгарав.

Сэтгүүлийнхээ энэ удаагийн дугаарт эхний 2 байрт шалгарсан оюутнуудын ЭССЭ-нийтлэлийг уншигч танд толилуулж байна.

ХЭНД, ЯАЖ, ЯМАР АРГААР

I байр
Ж.Энхжаргал, оюутан
МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль,
философиийн 4-р анги

*Хэн ч таныг харахгүй байгаа юм шиг бүжиглэ
Хэн ч сонсохгүй байгаа юм шиг чангаар дуул
Хэзээ ч шаналж байгаагүй юм шиг хайрлан дуул
Хэдийгээр дэлхий диваажин биш ч, диваажин юм шиг амьдар!*

1981 оны тэр нэгэн гунигтайхан өдөр хүн төрөлхтөнийг цочроосон нэгэн аймшигт үйл харанга дэлдсээр бидний дунд шургалан оржээ. Тиймээ, энэ бол нөгөөх бүрэн төгс эмчлэгддэггүй, гарсан цагасаа хойш 37.8 сая хүний амийг авч □ дэлхий дээрх нас баралтын 4 дэх шалтгаан болоод байгаа AIDS/ДОХ юм. Гэхдээ аюул дэгдээсэн энэхүү өвчин хэдийгээр бүрэн төгс эмчлэгддэггүй боловч шувууны ханиад, SARS шиг амьсгалын замаар халдвартараахгүй, гагцхүү өөрөө өөртөө дээд зэргийн сонор сэрэмж, анхаарал тавьж чадвал уг өвчинөөр халдвартана гэж айлтгүй ээ.

Анхаарал Тавь!. Тохиолдлын бэлгийн хавьталд орохгүй байх, зүү тариур зэрэгтэй болгоомжтой харьцааж аль болох ил шарх авахгүй байх, тохиолдлын бэлгийн харьцаанд орохгүй байх. Та зөвхөн эдгээрийг л тэвчиж чадвал танд ДОХ халдахгүй. Харин ДОХ-ын нэгэн аймшигт үнэн нь тэрээр эхийн сүүгээр, эхээс хүүхдэд халдах, аюул бий.

Хэдийгээр хүн болгон дээрхийг мэддэг ч ДОХ-ын нян тээгч, эсвэл ДОХ-оор өвчилсөн хүнтэй нэг л их аюултай, бушуухан л хажуугаас нь холдож цэрвэхгүй бол яг л ДОХ-той болох нь гэсэн байдлаар ханддаг нь тэдэнд ингэж амьдрахаар шуудхан л□ гэсэн бодол төрүүлчихдэг.

“6 жилийн өмнөх тэр нэгэн намрын жихүүн өдөр Хүний Дархлал Хомсдолын Вирусын халдвартай буюу ДОХ өвчний тээгч вирус гэдгийг мэдсэн тэр хар өдрийг би хэзээ ч мартааж чадахгүй”, “... мэдээж би халдвартай болсноо мэдээд ямар их гутарсныг минь хэлээд баршигүй”, “... би амиа хорлоё гэж бодож байлаа.”

“Би ойлгодоггүй. Яагаад ДОХ-ын халдвартай хүмүүсийг ялгаварлан гадуурхаж, элдэээр бичиж байдаг юм бэ? Хүмүүс миний тухай ямар ч бодолтой байлаа гэсэн тэднийг өөрийгөө өвчинөөс хамгаалах мэдлэгтэй чадвартай байгаасай гэж чин сэтгэлээсээ хүсч байна. Ертөнцийн төгсгөл болоогүй байна. Би ингэж бодох эрхтэй хүн билээ” /www.dotno.mn/

Хүний Дархлал Хомсдолын Вирус тээгч хүнийг бид ялгаварлан гадуурхаж жигшишнээр өнөөдөр дэлхий ДОХ хэмээгч өвчингүй болчихгүй. Харин түүний талаарх мэдээ, мэдээллийг хүртээмжтэй байдлаар олон нийтэд ялангуяа эмэгтэйчүүдэд, хүүхэд залуучуудад энэ талын мэдлэгийг тэдний онцлогт тохируулан зөв зүйтэй арга замаар өгөх нь чухал юм. Учир нь дэлхий дээрх нийт ДОХ-ын нян тээгч 37.8 сая хүний 30 гаруй хувь нь 25-аас доош насны хүмүүс

бөгөөд эдгээрийн 2/3-ыг нь эмэгтэйчүүд эзэлж, 15-24 наасны 12 сая хүүхэд, залуучууд ХДХВ-гийн халдвартай амьдарч байгаа бөгөөд өдөрт 6000 залуучууд шинээр ХДХВ-гийн халдвар авч байна. Энэ бүгдээс үзэхэд уг өвчний эсрэг тэмцэхдээ хэнд хандсан үйл ажиллагаа явуулах нь үр дүнтэй болох нь ойлгомжтой боллоо. ДОХ-ын талаарх хүмүүст ойлгогддог буруу мэдээллийг залруулах үүднээс хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон түмний сэтгэл зүйд хандсан нэвтрүүлгүүдийг зөвхөн дэлхий нийтээр ДОХ-той тэмцэх 12 сарын 1-ний өдөр явуулах бус улирал, сар болгон үүнтэй холбоотой мэдээллийг олон түмэнд хүртээмжтэй байдлаар тархааж, ойлгуулах хэрэгтэй байна. Мөн бэлгийн замын халдварт өвчинөөр өвчилөх эрсдэл бүх биеэ үнэлэгч хүмүүст бэлгийн замын халдварт өвчин хийгээд түүнээс үүдэх хор хохирол ДОХ-ын тухай мэдээллийг өгдөг ИТГЭЛ төслийн хугацаа дуусах тохиолдолд цааш үргэлжлүүлэн, 10 жилийнхний дунд гэр бүл хичээлийг ДОХ-той тэмцэх өдөртөй холбогдуулан зохиочход орхих биш цаашид үргэлжлүүлэх шаардлагатай байна.